

**НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО (ӨБХ)-НООС ХИЙЖ  
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2013.02.07.

Улаанбаатар хот

УИХ-ын 2012-2013 оны намрын ээлжит чуулганы хугацаанд тус Байнгын хорооноос хийж гүйцэтгэсэн ажлын дийлэнх нь шинээр байгуулагдаж буй ӨБХ-ны ажиллах нөхцөл, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн. Тус Байнгын хорооны ажлын алба нь Байнгын хорооны өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журам болон түүнтэй холбоотой зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах, УИХ-аас иргэдтэй харилцах, иргэдээс УИХ-д хандаж гаргасан өргөдлийг шийдвэрлэхтэй холбоотой бүх үйл ажиллагааг шинэчлэхтэй уялдуулж судалгааны ажил, санал, дүгнэлт гаргаж ажиллав.

***а/. Эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр болон хууль тогтоолын төсөл дээр ажилласан талаар :***

Ээлжит чуулганы хугацаанд ӨБХ 3 удаа нийт 3 цаг 35 минутын хугацаагаар хуралдаж ӨБХ-ны даргыг томилох болон Байнгын хорооноос 201.08.17-11.07-ны хооронд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцэж, Намрын чуулганы хугацаанд хийх ажлын төлөвлөгөө болон **Байнгын хорооны дүрмийг батлав.**

ӨБХ-ны ажлын албаны орон тоо, бүтцийн төслийг судалгааны үндсэн дээр гаргав.ӨБХ-ны эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр Байнгын хорооны гишүүн Х.Тэмүүжин, М.Батчимэг нар болон судлаачтай 2 удаа, ажлын албаны зүгээс судлаачидтай хамтран 4 удаагийн уулзалтууд зохион байгуулав.

ӨБХ-ны дүрмийг батлуулж, холбогдох хуульд өөрчлөлт оруулах төслийг боловсруулав.ӨБХ-ны эрх зүйн орчинтой бүрдүүлэхтэй холбоотой дүрэм, журам, хуулийн төсөл боловсруулахтай холбоотой гадаад улсын 88 орны парламентын судалгаатай танилцан ӨБХ-той 5 улс буюу ХБНГУ, Австрали, Шотланд, Англи, Энэтхэг Улсын ӨБХ-ны үйл ажиллагааг нарийвчлан судлав.

Өргөдлийн байнгын хорооны үйл ажиллагааг иргэдэд таниулах, өргөдөл бичих загвар, өргөдөл бичих талаар иргэдэд зориулсан хөтөч, ӨБХ-ны танилцуулга зэргээр гарын авлага, товхимол хийх ажлыг хийж байна.

ӨБХ-ны эрх зүйн орчинг бүрдүүлэхтэй холбоотой хийгдэх ажлын төлөвлөгөө, иргэдийн хувийн хүсэлтийн талаар бодлогын шийдэл гаргах ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргав.

Уг төлөвлөгөөнд дүрэм боловсруулахаас эхлээд иргэд, УИХ-ын дотоодод шинэ дүрэм, журмыг тайлбарлан таниулах сургалт, сурталчилгаа олон нийтэд мэдээлэх чиглэлээр телевиз, радио, сэтгүүл, сонин, вэб сайтад гаргах ажлуудыг нарийвчлан тусгасан.

УИХ-д ирүүлж байгаа иргэдийн хувийн хүсэлт, (гэр, орон сууц, сургалтын төлбөр хүссэн өргөдөл)-ийг агуулгаар нь судлах, гаргаж байгаа шалтгааныг гаргах, УИХ-аас хэрхэн шийдвэрлэж байх талаар бодлогын шийдэл гаргах судалгааны ажлын хэсгийг байгуулан, судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Судалгааны ажлыг үндэслэн хийсэн хэлэлцүүлгийн хүрээнд хувийн хүсэлтийг шийдвэрлэх бодлогын хувилбарын талаар ярилцаж нэгтгэсэн танилцуулга, гарын авлага бэлтгэхээр ажиллаж байна.

Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах журмыг боловсруулах чиглэлээр өөрийн орны хууль тогтоомж болон гадаад орны туршлагыг судалж байна.

Мэдээллийн ил байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өргөдлийг хэрхэн шийдвэрлэх талаар дүгнэлт гаргахаар ажиллаж байна.

Гадаад орны туршлага судлах судалгааны чиглэлээр тодорхой ажлуудыг хийв.

ӨБХ-ны эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн дүрэм, журам, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажилд гадаад орнуудын туршлагыг харуулсан харьцуулсан судалгааг гаргуулахаар судалгааны төвд 2 хариутай бичиг хүргүүлсэн.

Судалгааны төвөөс Австрали, ХБНГУ, БНЭУ-ын Өргөдлийн байнгын хорооны ажиллах чиг үүрэг, журам, Гэрч болон бүрдүүлсэн материалыг хамгаалах асуудал, парламентыг үл хүндэтгэх үед хүлээлгэх хариуцлагын талаар ирүүлсэн судалгааг хүлээн авч ажлын албанд танилцуулаа.

Энэ ажлын хүрээнд Байнгын хорооны гишүүд, ажлын албаны ажилтнуудыг бусад орны ӨБХ-ны үйл ажиллагаатай танилцуулах, богино хугацааны сургалтанд хамруулах, туршлага солилцох болон ӨБХ-ны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжлүүлэх чиглэлээр НҮБ, Канад, Австрали, Швецарь, АНУ, ХБНГУ, Солонгосын холбогдох байгууллага, албан хаагчтай уулзалт зохион байгуулж, зарим ажлуудыг эхлүүлээд байна.

Гадаад, дотоодын байгууллага, иргэдэд тус Байнгын хорооны цаашдын үйл ажиллагааг урьдчилсан байдлаар танилцуулах зорилгоор төсөөлж гаргасан товч

танилцуулга, Байнгын хороо ажиллах процедурыг схем байдлаар тус тус монгол хэл дээр бэлтгэн англи хэл дээр орчуулав.

ХБНГУ-ын ӨБХ-той ӨБХ-ны дарга Р.Бурмаа, ӨБХ-ны гишүүн М.Батчимэг нарын нийт 5 төлөөлөгч танилцах ажлыг зохион байгуулж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэв.

#### ***б/ УИХ-ын хяналт шалгалтын ажлын талаар***

ӨБХ-ны дүрмийн төслийг боловсруулах судалгааны ажлын хэсгийг байгуулсан.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу Нийгмийн бодлогын байнгын хороотой нээлттэй хэлэлцүүлэг хийх үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг боловсруулсан.

Түүнчлэн "Газрын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг хянан шалгах, хэлэлцүүлэг зохион байгуулах" үүрэг бүхий Ажлыг хэсэг байгуулан холбогдох судалгааны ажлыг хийж байна.

#### ***в/ Дотоод ажлын чиглэлээр болон бусад ажлын талаар***

УИХ-ын дарга, гишүүд, тамгын газрын удирдлагад 2008-2012 онд хандаж гаргасан иргэдийн өргөдлийн шийдвэрлэлтийн байдлын танилцуулгыг бэлтгэв.

УИХ-ын дарга, гишүүд, Байнгын хороо, дэд хороодод ирүүлсэн нийт 1300 өргөдлийг хүлээн авч бүртгэн, ангиллын дагуу картын бүртгэл хөтөлж, УИХ-ын ажлын алба болон холбогдох Байнгын хороодод хүлээлгэн өгч, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллав.

Иргэдээс ӨБХ-нд ирүүлсэн нийт (370 /400/ ) өргөдлийг хугацаанд нь судлан, шийдвэрлэв. Хугацаа хоцорсон өргөдөл байхгүй.

Өргөдлийг хүлээн авах, ангилах, хариу өгөх одоогийн УИХ-ын үйл ажиллагааг судалж, хүндрэлтэй, зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг гарган, шийдвэрлэх арга замын талаарх санал дүгнэлт, бүдүүвчийг гаргасан.

ӨБХ-ны ажиллах нөхцөлд дэмжлэг хүссэн 1, УИХ-ын өргөдлийг хүлээн авах, ангилах үйл ажиллагааг сайжруулах чиглэлийн саналын талаарх 1 хариутай албан тоотыг бэлтгэн УИХ-ын дарга, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий бичгийн дарга нарт тус тус хүргүүлсэн.

УИХ-ын гишүүний бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар иргэдээс гаргасан өргөдлийг /нийт 753/ ажлын 3 хоногийн дотор харъяаллын дагуу холбогдох

байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэлтийн талаар хяналт тавин ажиллаж байна.

Тус Байнгын хороонд нийт 218 албан бичиг ирснээс Байнгын хорооны даргын нэр 218 албан бичиг ирж хариутай 30 бичгийн хариуг хугацаанд нь шийдвэрлэсэн. Байнгын хорооноос нийт 170 албан бичиг холбогдох байгууллагууд руу явуулсан.

УИХ-ын өргөдөл хүлээн авах, ангилах программыг сайжруулах, УИХ-ын вэб сайтанд өргөдлийг цахим хэлбэрээр хүлээн авах боломжтой болгохоор шинэ программ, вэбсайтын загварын талаар санал боловсруулсан.

ӨБХ-ны дүрмийн төслийг боловсруулах судалгааны ажлын хэсэг байгуулагдан ажиллаж ажлаа дуусгасан.

“УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны /ӨБХ-ны/ үйл ажиллагааны чиглэл, цаашдын чиг хандлага сэдэвт уулзалт-хэлэлцүүлгийг 2013.01.16-нд зохион байгуулж УИХ-ын ӨБХ-ны гишүүд, Ажлын алба, УИХ-ын Тамгын газрын хэлтсийн дарга нар, Захидал харилцааны ажилтнууд, УИХ-ын судалгааны төвийн зарим ажилтнууд, Бүгд Найрамдахчуудын хүрээлэнгийн Монгол Улс дахь хөтөлбөрийн захирал, ажилтан, УИХ-ын гишүүдийн зөвлөх, туслахууд, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Өргөдлийн хорооны гишүүд, Ажлын алба, Нийслэлийн захирагчийн ажлын албаны өргөдлийн шийдвэрлэлт хариуцсан ажилтнууд, Ерөнхийлөгчийн Тамгын газар болон ЗГХЭГ-ын захидал харилцааны алба, иргэдийг хүлээн авах ажилтнууд, “1111” төвийн ажилтнуудыг оролцуулж санал солилцлоо.

Өргөдлийг хүлээн авах, ангилах программыг шинэчлэх судалгааны ажил хийгдэж байгаагийн зэрэгцээ ӨБХ-ны вэб сайт бий болгох, вэб сайт нь одоо ажиллаж байгаа дотоод сүлжээтэй хэрхэн уялдаа холбоотой ажиллах талаар УИХ-ын ТГ-ын Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтсийн ажилтнуудтай уулзаж санал солилцлоо.

ӨБХ-ны үйл ажиллагаа, түүний танилцуулга, өргөдөл бичих загвар, өргөдөл бичих талаар иргэдэд зориулсан хөтөч зэргээр телевизийн нэвтрүүлэг бэлтгүүлэх, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээх бэлтгэл ажлыг хийж байна.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО